



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/208

Улаанбаатар хот

Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан
хариу арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн 1 дүгээр хороонд халаалтын шугам, паар 2024 оны 11 дүгээр сарын 11-ний үүрийн 05 цагт задарч ус алдан 1 дүгээр хорооны 1 давхар болон подваль усанд автаж төрийн анхан шатны үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл учран хэвийн үйл ажиллагаа доголдож байгаа тул урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг 1 дүгээр хороо (Н.Нямзав)-д үүрэг болгосугай.

2. Хор уршгийг арилгахад зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3.1 дүгээр хороонд халаалтын шугам засварлах 1,984,000 (Нэг сая есөн зуун наян дөрвөн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, Гамшиг үүссэн нөхцөл байдлыг арилгаж, төрийн анхан шатны үйлчилгээг хэвийн явуулахад анхаарч ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны..... дугаар сарын ны өдрийн
Авс. дугаар захирамжийн хавсралт



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН 1 ДҮГЭЭР ХОРООНД
ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ МАТЕРИАЛЫН ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Паар	ширхэг	16	22000	352,000
2	Замаска	ширхэг	15	14000	210,000
3	Хөөсөн тааз	ширхэг	76	8000	608,000
4	Хүрээ	ширхэг	76	4500	342,000
5	Эмүльс (18л)	л	2	90,000	180,000
6	Премент	ширхэг	1	5500	5,500
7	Цилкон	ширхэг	30	7500	225,000
8	Өнхрүүш	ширхэг	3	7500	22,500
9	Шпатал	ширхэг	6	1500	9,000
10	Зүлгүүр	м ²	5	2000	10,000
11	Канап	ширхэг	1	20000	20,000
Нийт дүн					1,984,000